

Чингэлтэй дүүргийн Эрүүл мэндийн нэгдэл

Нийслэлийн Чингэлтэй дүүргийн нь 3,5 гектар га нутаг дэвсгэртэй, 19 хороодын нийт 136891 гаруй хүн амд нийгмийн эрүүл мэнд, эмнэлгийн анхан шатны болон хоёрдогч шатлалын тусламж үйлчилгээг 18 өрхийн эмнэлэг, нарийн мэргэжлийн поликлиник салбар амбулаториуд, хэвтэн эмчлүүлэх стационариар дамжуулан үзүүлдэг төрийн үйлчилгээний байгууллага юм.

1985 оны 04 дүгээр сарын 15-анд Сүхбаатар дүүргийн Нэгдсэн Эмнэлэг, 1990 оны Нэгдсэн 4 дүгээр эмнэлэг болж улмаар 1997 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс албан ёсоор "Чингэлтэй ЭМН-ийн нэртэй болж үйл ажиллагаагаа явуулж байна.

Удирдлага-НЭМ-ийн - Хэвтэн эмчлүүлэх эмнэлэг- Поликлиник-Чанарын алба- Санхүү, аж ахуйн алба- Туслах нэгж Эмийн сан ариутгал, Угаалга-Нэгдүгээр амбулатори- 2 дугаар амбулатори

Хүний нөөцийн байдал

91 их эмч

120 эмнэлгийн дунд мэргэжилтэн

96 туслах болон үйлчилгээний ажилтан нийт 307 хүний бүрэлдэхүүнтэй

1. Поликлиник
2. Амбулатори
3. Амбулатори
4. Хэвтэн эмчлүүлэх 167 ор бүхий стационар

НЭМ-ийн тасаг

НЭМ-ийн тасаг нь 2007 онд байгуулагдсан НЭМ-ийн болон ЭМ-ийн анхан шатны тусламж үйлчилгээний чиглэлээр 19 хороодын 18 өрхийн эмнэлгүүдээр дамжуулан үйл ажиллагаагаа явуулж байна. НЭМ-ийн тасаг нь үндсэн 6 багаас бүрддэг.

1.Эпидемиологи-биостатистикч эрүүл мэндийн мэдээлэл зүйн баг дүүргийн хүн амын өвчлөлийн талаарх болон ЭМН-ийн эмнэлгийн тусламжийн үйл ажиллагааны үзүүлэлтүүдийн талаарх мэдээ мэдээллийг бүртгэх, нэгтгэх, шинжлэх , дүгнэж дээд шатны удирдах, мэргэжлийн байгууллагуудтай мэдээлэл солилцоо, үйл-ажиллагааны тайлан мэдээ дамжуулах хүлээн авах чиглэлээр хамтран ажиллах, зөвлөгөө авах, цаашид өрхийн болон ЭМН-ийн төвшинд цахим тогтолцоог хөгжүүлэхээр зорин биостатистикч их эмч, АУ-ны магистр С.Ганшүр, статистикт баг эмч Ц.Лувсмаа эрүүл мэдээллийн технологич Т.Асрагчмаа нар ажиллаж байна.

2.Өрхийн менежментийн баг Чингэлтэй дүүргийн нийт 19 хороодод үйл ажиллагаагаа явуулж буй 18 өрхийн эмнэлгүүдийн НЭМГ-ын болон Чингэлтэй дүүргийн ЗДТГ,ЭМН-тэй байгуулсан гурвалсан гэрээний биелэлтийг хэрэгжүүлэхэд мэргэжил арга зүйгээр хангах, үйл ажиллагааны чанарыг үнэлэх зорилгоор өрхийн менежер, ахлах эмч Т.Нямжав болон өрхийн чанарын менежер, АУ-ны магистр Б.Булганмаа нар ажиллаж байна.

3. Үндэсний эрүүл мэндийн хөтөлбөрүүдийн баг : МУ-ын Засгийн газраас хэрэгжүүлж байгаа эрүүл мэндийн үндэсний хөтөлбөрүүдийг хариуцсан эмч нараас бүрддэг баг

4. Хүүхэд өсвөр үе баг ХӨЦМ-ийн чиглэлээр болон өсвөр үеийн кабинет ийн эмч нар хамтран ажилладаг. Түүхчлэн хүүхдийн түргэн тусламж болон Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэрт харьяалагдах 11 ЕБС-уд, 24 цэцэрлэгийн эмч нартай хамтран ажилладаг.

5. Эрүүл мэнд сургалт. эрдэм шинжилгээ, судалгаа, гадаад харилцааны баг-Эрүүл мэндийн зан үйлийг төлөвшүүлэхэд чиглэсэн эрүүл мэндийн сайн санааны туслагч нараар дамжуулан ард иргэдийн оролцоо идэвхийг хөгжүүлэх, нийгэмд болон дүүрэгт тулгамдаж буй өвчин эмгэгүүдээс урьдчилан сэргийлэх, хамтын хүчээр энэ бүх шатандаа хамтарч ярилцаж, зөвлөн шийдвэрлэж болохоор зорин ажиллаж байна.